

БАТЛАВ.
УЛСЫН АМГАЛАН
АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
М.Мөнхөө
М.МӨНХӨӨ

БАТЛАВ.
УЛААНБААТАР ХОТ
НАЛАЙХ
НАЛАЙХ ДҮҮРГИЙН ТОХИЖИЛТ
ҮЙЛЧИЛГЭЭ ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
Ц.ЭРБОЛ

**НАРИЙН ҮНС ХҮЛЭЭН АВАХ, ДАРЖ БУЛАХ, НЯГТРУУЛАХ,
ХӨРСӨӨР ХУЧИХ АЖЛЫН ГЭРЭЭ**

Дугаар № *2023/116*

20*23* оны *12* сарын *13*

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Амгалан дулааны станц ТӨХК –ийг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Мөнхөө /цаашид захиалагч гэх/ нөгөө талаас Улаанбаатар хотын Налайх дүүргийн Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын дарга Ц.Эрбол /цаашид гүйцэтгэгч гэх/ хамтад нь/ цаашид талууд гэх / нар нь Монгол Улсын Иргэний Хуулийн 343-358 дугаар зүйл, Монгол улсын Хог хаягдлын тухай хууль, Налайх дүүргийн ИргэдийнТөлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн "Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 19/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээний зорилго

1.1 Гэрээний зорилго нь захиалагчийн буулгасан "Налайх дүүргийн төвлөрсөн хогийн цэгт хүлээн авах, дарж булах, нягтруулах, хөрсөөр хучих" ажлыг дор дурдсан хугацаанд чанартай гүйцэтгэх, Захиалагч нь гүйцэтгэсэн ажлыг дүгнэж зохих шаардлагыг хангасан гэж үзвэл энэхүү гэрээгээр тохирсон хугацаанд ажлын хөлсийг төлөх, харилцан үүрэг хүлээх, хариуцлагыг тогтоох, ажил эхлэх, гүйцэтгэх, дуусах явцтай холбоотой үүссэн харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Гэрээний нөхцөл , ерөнхий зүйл, хугацаа

2.1 Гүйцэтгэгч нь захиалагчийн буулгасан нарийн үнсийг "Налайх дүүргийн төвлөрсөн хогийн цэгт хүлээн авах, дарж булах, нягтруулах, хөрсөөр хучих" (цаашид "ажил" гэх)-ыг энэхүү ажлыг 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр дуусгах ба 1 /нэг/ жилийн хугацаанд багтаан гүйцэтгэнэ.

Гурав. Төлбөр тооцоо

3.1 Гэрээт ажилд /Налайх дүүргийн ИргэдийнТөлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн"Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 19/04 дүгээр тогтоолоор батлагдсан үнийн тарифыг дагаж мөрдөнө/. Нэг тонн

нарийн үнсийг 10,000 /Арван мянган/ төгрөг байхаар талууд харилцан тохиролцов. НӨАТ багтсан үнэ болно, гэрээний хугацаанд үнэ тогтмол байна.

3.2 Гэрээт ажилд урьдчилгаа төлбөр төлөхгүй.

3.3 Гэрээт ажлын төлбөрийг дараа сарын эхний 5 /тав/ хоногийн дотор гүйцэтгэлээр тооцоо нийлж, нэхэмжлэхийн дагуу гүйцэтгэгчийн ХААН банкны 5749062084 тоот дансанд шилжүүлнэ.

3.4 Талууд гэрээг цуцлах талаар санал гаргаагүй тохиолдолд гэрээг анх байгуулсан нөхцөл, хугацаагаар дахин нэг жил сунгасанд тооцно.

Дөрөв. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

4.1 Гэрээт ажлыг гэрээний үнэд багтаан чанартай хийж гүйцэтгэнэ.

4.2 Буулгасан нарийн үнсийг хүлээн авч механизмаар түрж булах, нягтруулах, хөрсөөр хучих ажлыг гүйцэтгэнэ.

4.3 Гэрээт ажлыг гүйцэтгэхдээ ажилтнуудаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангуулж, машин механизмын бүрэн бүтэн байдлыг хангуулах, цахилгааны болон галын аюулаас урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг авч ажиллана.

4.4 Ажил гүйцэтгэх хугацаанд холбогдох хууль, дүрэм журмыг мөрдөж ажиллана. Захиалагчийн тавьсан хууль ёсны шаардлага зөвлөмжийг заавал биелүүлнэ.

4.5 Гүйцэтгэгч тал захиалагчийн зөвшөөрөлгүйгээр гэрээний эрх үүрэг, хариуцлагыг бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй.

Тав. Захиалагчийн эрх, үүрэг

5.1 Захиалагч зуухнаас гарсан нарийн үнсийг өөрийн эзэмшлийн нарийн үнс тээвэрлэх зориулалтын автомашинаар Налайх дүүргийн 3-р хороонд байрлах төвлөрсөн хогийн цэгт заагдсан газарт буулгана.

5.2 ХАБ, ГАБ, техникийн бүрэн бүтэн байдлын шаардлагыг биелүүлэхээс татгалзсан эсэргүүцсэн, дүрэм, стандартыг зөрчсөн ажлын гологдол гаргасан тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээг авах эрхтэй.

5.3 Гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэсэн ажилтай холбоотой зөрчил, доголдол гарвал үнэ төлбөргүй хийж гүйцэтгэхийг шаардах эрхтэй.

5.4 Ажил гүйцэтгэх явцад гүйцэтгэгчийн ажилд захиалагч талаас хяналтыг тогтмол тавьж ажиллана.

5.5 Захиалагч нь пүү ажиллуулж байгаа ажилтнаас үнс буулгасны дараа пүүний баримтаа авах бөгөөд тооцоо нийлэх үед баримт болгох.

5.6 Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллана.

5.7 Тээвэрлэн ирэх нарийн үнсний галыг бүрэн унтраасан байх ба Налайх дүүргийн Төвлөрсөн хогийн цэгт галын аюулгүй байдлыг хангахгүйгээр галтай үнс буулгаснаас гарах хохирлыг бүрэн барагдуулах.

Зургаа. Талуудын хүлээх үүрэг хариуцлага

6.1 Гүйцэтгэгчийн буруугаас гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,1 %-иар хоног тутам гүйцэтгэгч алданги хүлээх ба уг алданги нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.

- 6.2 Захиалагчийн буруугаас төлбөр төлөх хугацаа хэтэрвэл гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,1 % -ийн алданги хүлээх ба үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.
- 6.3 Нэг жилийн дотор гүйцэтгэсэн ажлын чанар шаардлага хангахгүй алдаа гарвал захиалагч нь мэдсэн өдрөөс хойш гүйцэтгэгчид мэдэгдэж гүйцэтгэгч нь ажлын 3 хоногийн дотор өөрсдийн хөрөнгөөр хэвийн болгож хүлээлгэн өгөх үүрэгтэй.
- 6.4 Алданги төлсөн нь үндсэн үүрэг болон учирсан хохирлыг төлөх үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.
- 6.5 Захиалагчийн саналаар нэмэлт ажил хийгдэх, үнийн ямар нэгэн зөрүү гарсан тухай бүр 2 /хоёр/ тал харилцан тохиролцож акт протоколоор баталгаажуулж шийдвэрлэнэ.
- 6.6 Захиалагчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг "Амгалан дулааны станц" ТӨХК-ийн Гэрээ,борлуулалтын инженер Б.Батцоож хариуцан ажиллана. Утас-99662289, 88782289.
- 6.7 Гүйцэтгэгчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг Налайх дүүргийн Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын орлогын байцагч С.Оюунгэрэл хариуцан ажиллана. Утас-96561256, 88621256.

Долоо. Давагдашгүй хүчин зүйл

- 7.1 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал гэдэгт үерт автах гал түймэрт нэрвэгдэх, дэлбэрэлтэд өртөх газар хөдлөх, зуд болох, тахал болон байгалийн бусад хүчин зүйлс мөн цэрэг дайны үйл ажиллагаа төрийн эрх барих байгууллагын шийдвэр буюу экспорт импортын хориг ажил хаялт үйлдвэрлэгчийн бүх төрлийн сул зогсолт зэрэг энэ гэрээг зохих ёсоор биелүүлэх боломжгүй байдлыг бий болгохыг ойлгоно.
- 7.2 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээ биелэгдэх боломжгүй болсон бол талууд бие биедээ нэн даруй мэдэгдэх ба гэрээт хугацаан дээрх нөхцөл байдал арилгах хүртэл хугацаагаар сунгагдах буюу нэг талын санаачилгаар цуцална.
- 7.3 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлыг зохиомлоор буюу болгоомжгүйгээр бий болгосноос бусад тохиолдолд учирсан хохирлыг хариуцах үүргээс талууд чөлөөлөгдөнө.
- 7.4 Гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн бол талууд нэн даруй харилцан биендээ албан бичгээр мэдэгдэнэ.

Найм. Гэрээг цуцлах, нэмэлт өөрчлөлт оруулах

- 8.1 Энэхүү гэрээнд заасан үүргээ талууд ноцтой зөрчсөн буюу хуульд заасан үндэслэл бий болсон бол талууд хэдийд ч гэрээг цуцлах эрхтэй.
- 8.2 Хэрвээ талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарвал урьдчилан тохиролцон хавсралтаар оруулж гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулснаар гэрээний нэгэн адил хууль зүйн хүчинтэй.
- 8.3 Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажил гүйцэтгэх хугацаа хожимдуулсан, ноцтой зөрчил гаргасан цаашид уг ажлыг үргэлжлүүлэх боломжгүй болсон тохиолдолд захиалагчийн санаачилгаар гэрээг цуцална.
- 8.4 Гэрээний сунгалт, нэмэлт өөрчлөлтүүд нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 8.5 Хэрэв аль нэг тал гэрээг цуцлах саналтай бол нөгөө талдаа 1 /нэг/ сарын өмнө албан бичгээр мэдэгдэж гэрээг цуцалсан тухай акт үйлдэн үйлчилгээ, төлбөр тооцоог дуусгавар болгоно.

Ес. Бусад зүйл

- 9.1 Энэхүү гэрээний үйлчлэл нь талууд гарын үсэг зурж тамга дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж, талууд тус тусын үүргээ биелүүлж гэрээг дүгнэснээр дуусгавар болно.
- 9.2 Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3 Гэрээг монгол хэл дээр 2 хувь үйлдэж Захиалагч 1 хувийг Гүйцэтгэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 9.4 Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс эхэлж хүчин төгөлдөр болно.
- 9.5 Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

Э. МӨНХЖАРГАЛ
СЭЗХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ
НЯГТЛАН БОДОГЧ
ГЭРЭЭ,БОРЛУУДАЛТЫН ИНЖЕНЕР

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН

Ө.УДВАЛ
Б.БАТЦООЖ

С.САРУУЛ

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НАЛАЙХ ДҮҮРГИЙН ХОТ ТОХИЖИЛТ
ҮЙЛЧИЛГЭЭ ОНӨААТҮГ-ЫН ЕРӨНХИЙ
НЯГТЛАН БОДОГЧ
ОРЛОГЫН БАЙЦААГЧ

Б.УНДАРМАА

С.ОЮУНГЭРЭЛ

ХАЯГ:

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, 8-р хороо, Ботаникийн эцэс,
УС-15-1-1

Утасны дугаар: 77111257, 99662289, 99047300

РД: 6021646

Хаяг: Налайх дүүрэг 2-р хороо Хуульчды,
гудамж 14-р байр.

Утас: 88090034, 88055504, 88621256

РД: 2604663.